

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААН ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН А.ОТГОНБАЯРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин		Хүрсэн түвшин	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн Хувь
				Эхний хагас жил	Сүүлийн хагас жил			
	1	2	3	4	5	6	7	8
	Зорилт 1.1. Эх хэл, уламжлалт зан заншил, түүхээ дээдэлсэн, хотын соёлыг тээгч, зөв хүн болгон төлөвших үйл ажиллагааг иргэдийн дунд олон талт хэлбэрээр зохион байгуулах зорилтын хүрээнд:							
1.	1.2 Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг гэрээгээр хамгаалах өрхийн тоог нэмэгдүүлж иргэд олон нийтийн хяналт оролцоог сайжруулах	Иргэд олон нийтийн хяналт оролцоог хангасан эсэх	20 өрхтэй гэрээг шинэчилж сунгасан	20 өрхтэй гэрээг шинэчилж сунгасан байна.	-	2024 онд 20 өрхтэй гэрээг сунгаж харьяалах нутаг дэвсгэрт орших түүх, соёлын үл хөдлөх 28 дурсгалт газрын 343 булш, оршуулгын дурсгалын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлж аймгийн Засаг даргын захирамжаар нийт 6.0 сая төгрөгийн урамшууллыг дээрх 20 өрхөд олгосон.	2024.01.01 - 2024.12.31	100
2.	1.2 Түүхэн тэмдэглэлт өдрүүд болон Эрдэнэт хотын өдрөөр ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад тусгай хөтөлбөрөөр хичээл заах	Тэмдэглэлт өдрүүдээр тусгай хөтөлбөрийн дауу хичээл явагдсан байна.	Тэмдэглэлт өдрүүдээр тусгай хөтөлбөрийн дауу хичээл явагдсан	-	"Хэлмэгдэсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр", "Монгол бахархалын өдөр", "Улс тунхагласны өдөр", "Эрдэнэт хотын өдөр"-өөр тусгай хөтөлбөрийн дауу хичээл явагдсан байна.	ЕБС-ийн суралцагчдад эх орон, эв нэгдэл, үнэт зүйлээрээ бахархах үзэл төлөвшүүлэх, амьдран суугаа орон нутгаараа бахархах, хотын соёл, зөв дадал, хэвшлийг төлөвшүүлэх зорилго бүхий "Түүхэн тэмдэглэлт өдрүүд" сургалтын хөтөлбөрийг боловсруулж, жил бүр хэрэгжилтийг хангаж байна. Уг хөтөлбөр нь "Хэлмэгдэсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр", "Монгол бахархалын өдөр", "Эрдэнэт хотын өдөр", "Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярын өдөр" гэсэн 4 дэд хэсгээс бүрдсэн бөгөөд 2024-2025 оны хичээлийн жилд дээрх 4 хөтөлбөрт ерөнхий боловсролын сургуулийн 25,000 гаруй сурагч хамрагдсан байна.	2024.01.01 - 2024.12.31	100

3.	1.3 Соёл, урлагийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, хувцас хэрэглэлээр хангах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах	Шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, хувцас хэрэглэлээр хангагдсан соёл, урлагийн байгууллагын тоо	5 байгууллагыг хангасан	-	5 байгууллага	Тайлант хугацаанд "Аялгуу" соёлын төвд 27.0 сая, "Баянцэгаан" соёлын төвд 20.8 сая, аймгийн Соёл, урлагийн газарт 44.8 сая, Хүүхэд, залуучуудын театрт 95.0 сая, шинээр ашиглалтад орсон "Номын өргөө" цогцолборт 292.0 сая, нийт 479.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нийлүүлсэн байна.	2024.01.01 - 2024.12.31	100
4.	1.4 Хувийн хэвшил болон орон нутгийн мэргэжлийн урлагийн байгууллага, уран бүтээлчдэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах	Дэмжлэг үзүүлж хамтран ажилласан иргэд, байгууллагын тоо	9 уран бүтээлч, 4 байгууллагад дэмжлэг үзүүлсэн	6 уран бүтээлч, 3 байгууллага	6 уран бүтээлч, 3 байгууллага	Тайлант хугацаанд хувийн хэвшлийн 4 байгууллагад 35.5 сая, 7 иргэнд 18.3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Мөн аймгийн Хүүхэд, залуучуудын театрын шинэ уран бүтээл "Хөх төрийн бэрс" драмын жүжигт 98.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.	2024.01.01 - 2024.12.31	100
5.	1.5 Улсын хэмжээний шилдэг уран бүтээлийг орон нутгийн иргэдийн хүртээл болгоход дэмжлэг үзүүлэх	Шилдэг уран бүтээлийн орон нутгийн иргэдийн хүртээл болгосон эсэх	1 уран бүтээлийг иргэдийн хүртээл болгосон.	-	1 уран бүтээл	Улсын филармоний "Баян Монгол" чуулгын "Сэтгэлд хоногшсон дуунууд" тоглолтыг 2 удаа зохион байгуулж, орон нутгийн иргэдийн хүртээл болгосон.	2024.01.01 - 2024.12.31	100
6.	1.6 Орон нутагт гадаад, дотоодын жуулчдыг татах зорилгоор соёл, урлагийн арга хэмжээг зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2 арга хэмжээ зохион байгуулсан.	-	2 арга хэмжээ зохион байгуулна.	2024 онд аймгийн Гончигсүмлэн хийдтэй хамтран "Луу жилийн мөсөн шагайн хишиг харваа" тэмцээн, аймгийн Биеийн тамир спортын газартай хамтран "Эрдэнэт мөнгөн өвөл" спортын наадам, "Эрдэнэтийн бал" цэнгээнт бүжгийн наадам", "Баян-Өндөр" хайрхан, тэнгэрийн 7 бурхан одны тахилга зэрэг орон нутгийн онцлог бүхий соёлын, урлагийн арга хэмжээг зохион байгуулсан.	2024.01.01 - 2024.12.31	100
7.	1.7 Айргийн гозгорын археологийн малтлагыг зохион байгуулах	Малтлага судалгааны ажил явагдсан эсэх	Монгол улсын Үндэсний Музей, БНХАУ-ын Ардын Их сургуультай хамтарсан малтлага явагдсан.	-	Малтлага судалгааны ажил явагдсан байна.	2024 онд аймгийн Музей Монголын Үндэсний музейтэй хамтран Айргийн гозгорын дурсгалт газарт малтлага судалгааны ажлыг хийж, орон нутгийн төсвөөс 30.0 сая төгрөг зарцуулсан бөгөөд малтлагаас гарсан ваар, сувс, үсний сам зэрэг олдворуудыг Монголын үндэсний музейн Судалгаа, шинжилгээний	2024.01.01 - 2024.12.31	100

						лабораторид сэргээн засварлат хийж байна. Сэргээн засварлалт дууссаны дараа аймгийн Музейн үзмэрийн сан хөмрөгийг баяжуулахаар төлөвлөж байна.		
Зорилт 1.2. Байгууллага, иргэдийн дунд үндэсний монгол хэл, бичгээ эзэмших, ашиглах, сурталчлах ажлыг хүртээмжтэй хэлбэрээр зохион байгуулах зорилтын хүрээнд:								
8.	1.2.1 “Эх хэл-Эрдэнэт” хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Хөтөлбөрийг хэрэгжүүлж тухайн жилд төлөвлөгдсөн ажлуудыг хэрэгжилтийг бүрэн хангасан эсэх	85.4 хувь	-	100 хувь	Аймгийн ИТХ-ын 2021 оны 04 дүгээр тогтоолоор “Эх хэл-Эрдэнэт” хөтөлбөрийг батлуулсан. Хөтөлбөрийн хэрэгжилт 2021 онд 84.6 хувь, 2022 онд 82.3 хувь, 2023 онд 85.4 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна. Хөтөлбөрийн 2024 оны хэрэгжилт урьдчилсан гүйцэтгэлээр 90 хувьтай байна. 2021-2024 онд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын үр дүнд төрийн байгууллагуудын 90 хувь нь, хувийн хэвшлийн байгууллагуудын 15 хувь нь хос бичгийн хаягтай болсон байна. Мөн 2021-2024 онд монгол бичгийн анхан, дунд шатны сургалтуудад давхардсан тоогоор нийт 39 байгууллагын 1287 албан хаагчийг хамруулж, үндэсний бичгийн анхан, дунд шатны мэдлэг олгосон байна. Үндэсний статистикийн хорооноос 2021 онд явуулсан “Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа”-нд хамрагдсан төрийн албан хаагчдын 23 хувь нь “Үндэсний бичгийн мэдлэггүй” гэж хариулж байсан бол 2024 онд 20.4 хувь болж 2,6 хувиар буурсан, “Үндэсний бичгийн анхан шатны мэдлэгтэй” гэж хариулсан албан хаагчийн хувь 2021 онд 25,8 хувь байсан бол 2024 онд 31,1 болж 5,3 хувиар, “Үндэсний бичгийн дунд шатны мэдлэгтэй” гэж хариулсан албан хаагчийн хувь 2021 онд 31,3 хувь байсан бол 2024 онд 33,3 хувь болж 2 хувиар, үндэсний бичгийн мэдлэг “Маш сайн”, “Сайн” гэж	2024.01.01 - 2024.12.31	70

						хариулсан албан хаагчийн хувь 2021 онд 9,9 хувь байсан бол 2024 онд 11,7 хувь болж 1,8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Тус судалгаанд 2024 онд хамрагдсан 4652 төрийн албан хаагчийн 64,4 хувь нь буюу 2995 албан хаагч үндэсний бичгийн анхан, дунд шатны мэдлэгийг эзэмшсэн гэсэн судалгааны үр дүн гарсан байна. Тайлан хугацаанд аймгийн хэмжээнд нийт 116 төрийн байгууллагын хэвлэмэл хуудсыг хос бичигт шилжүүлж албан хэрэгт ашиглах боломжийг бүрдүүлсэн. ЕБС-ийн сургуулийн Монгол хэлний хичээлийн масс сургалтын чанар 2020 онд 45,3 хувь байсан бол 2021 онд 47,3 хувь, 2022 онд 53,4 хувь, 2023 онд 53,6 хувь, 2024 онд 57,4 хувь болж өссөн байна.		
Зорилт 1.3 Иргэд, хүүхэд, залуучуудыг нийгмийн ёс зүйг дээдэлсэн, өөрийн хотын үнэт зүйлсээр бахархдаг, эерэг харилцаа, хандлага бүхий ухамсарт зан үйлд суралцуулах зорилтын хүрээнд:								
9.	1.3.1 Соёл, урлагийн байгууллагуудын ажилтан, уран бүтээлчдийг мэргэжил дээшлүүлэх сургалтад үе шаттай хамруулах ажлыг зохион байгуулах	Мэргэжлийн сургалтад хамрагдсан ажилтан албан хаагчдын тоо	Давхардсан тоогоор 53 ажилтан, албан хаагчийг мэргэжлийн сургалтад хамруулсан.	-	63	2024 онд Монгол бичгийн сургалтад соёл, урлагийн салбарын 32 албан хаагч, аймгийн Хүүхэд, залуучуудын театрт явагдсан "Хүүхэлдэй амилахуй" мэргэжлийн сургалт болон тайзны хөдөлгөөний 14 хоногийн сургалтуудад тус театрын 14 жүжигчин хамрагдсан байна. Мөн аймгийн Музейн дарга Ч.Энхтуяаг Хонконгт зохион байгуулагдсан "Museum summit-2024" олон улсын хөтөлбөрт арга хэмжээнд оролцож мэргэжил дээшлүүлэхэд 2.8 сая төгрөг, соёл, урлагийн салбарын 100 албан хаагчийн морин хуурын сургалтад 10.8 сая төгрөгийн дэмжлэгийг орон нутгийн төсвөөс олгосон байна. Мөн соёлын яамнаас зохион байгуулсан гэрэл, дууны техник, тайзны тоног төхөөрөмжийн мэргэжлийн сургалтад "Баян-Өндөр", "Баянцагаан" соёлын төвийн 2 ажилтан, СУИС-ийн эчнээ	2024.01.01 - 2024.12.31	100

						хөтөлбөрт "Аялгуу" соёлын төвийн 2 ажилтан тус тус суралцаж байна. 2024 оны байдлаар соёл, урлагийн салбарын мэргэжлийн боловсон хүчний хангалт 84 хувьтай байна.		
10.	1.3.2 Номын өргөө бүхий цогцолбор барилгыг ашиглалтад оруулах	Барилгыг ашиглалтад хүлээн авсан эсэх	-	Барилгыг ашиглалтад хүлээн авна.	-	Орон нутгийн төсвийн 4,9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар баригдсан "Номын өргөө" цогцолборын барилгыг 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр ашиглалтад хүлээн авсан.	2024.01.01 - 2024.04.25	100
Зорилт 2.1. Боловсролын үйлчилгээг тэгш, чанартай зохион байгуулан, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:								
11.	2.1.1 Чандмань багийн 150 хүүхдийн цэцэрлэгийг ашиглалтад хүлээж авах, 3,8 дугаар сургуулийн барилгын ажлыг хэвийн үргэлжлүүлэх, 2А, 7А хороололд 960 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын ажлыг эхлүүлэх	Ашиглалтад хүлээн авсан барилга, хэвийн үргэлжилж буй барилга, шинээр эхлэх барилгын тоо	3 барилгын ажил хэвийн үргэлжилсэн.	1 барилгыг ашиглалтад хүлээн авна.	2 барилгын ажил хэвийн үргэлжилж, 2 барилгын ажил шинээр эхэлнэ.	Чандмань багийн 150 хүүхдийн цэцэрлэг, "Уран эгшиг" сургуулийн өргөтгөлийн барилгуудыг ашиглалтад хүлээн авч үйл ажиллагааг эхлүүлсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж 3 дугаар сургуулийн барилгын ажилд 4.2 тэрбум төгрөг, 8 дугаар сургуулийн барилгад 3.2 тэрбум төгрөг тус тус батлагдаж барилгын ажил хэвийн үргэлжилсэн. Мөн 2А хорооллын 960 хүүхдийн сургуульд 4.7 тэрбум, 150 хүүхдийн цэцэрлэгт 1.8 тэрбум, 7А хорооллын 960 хүүхдийн суудалтай сургуулийн барилгад 4.7 тэрбум төгрөг тус тус батлагдсанаас 7А хорооллын 960 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын ажил, "Ирээдүйн одод" сургуулийн дотуур байрны барилгын ажлууд тус тус эхэлсэн байна.	2024.01.01 - 2024.12.31	100
12.	2.1.2 Сургууль, цэцэрлэгийн барилгад засвар хийж сургалтын сайжруулах	Засвар үйлчилгээ хийгдсэн байгууллагын тоо	10 байгууллагад засвар үйлчилгээ хийгдсэн.	-	8 байгууллагад засвар үйлчилгээ хийгдсэн байна.	Тайлант хугацаанд сургалтын 8 байгууллагад орон нутгийн төсвийн 1.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар шаардлагатай засвар үйлчилгээ хийгдсэн байна.	2024.01.01 - 2024.12.31	100
13.	2.1.3 ЕБС-иудын ахлах ангиудад байгалийн ухаан, математик, гадаад хэл, техник технологи, спорт, эрүүл мэнд, ёс зүй, урлагийн боловсрол олгох сургалтыг	Хэрэгжүүлсэн төслийн тоо	3 төсөл хэрэгжүүлсэн	-	3 төсөл хэрэгжүүлсэн байна.	Аймгийн Засаг даргын Тамгын газар Боловсрол, шинжлэх ухааны газартай хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулах "Тэгш боломж", сургуулийн насны хүүхдүүдэд эрүүл мэндийн	2024.01.01 - 2024.12.31	70

28

	төрөлжсөн хэлбэрээр зохион байгуулах					боловсролыг шинэлэг хэлбэрээр олгох “Эрүүл хүүхэд”, сурагчдад урлаг, спорт, гоо зүй, технологи, амьдрах ухааны боловсрол олгох “Хүүхдийн хөгжил” төслүүдийг 2022 оноос амжилттай хэрэгжүүлж байна. Эдгээр төслүүдийн хүрээнд 2024 онуудад онуудад орон нутгийн төсвийн 150.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 3 сургуульд “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих танхим”, 50.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 1 сургуульд “Эрүүл мэндийн жишиг кабинет” байгуулагдаж, төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиудад 150.0 сая төгрөгийн хөгжим, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн олгогдсон. “Хүүхдийн хөгжил” төслийн хүрээнд • Аймгийн аварга шалгаруулах “Степ аэробик”-ийн тэмцээн • “Аз жаргалтай аялгуу”-аймгийн үкүлэлэ, гитар хөгжмийн уралдаан • Гитар“Өглөөний цайг өөртөө” гидропоник төхөөрөмж ашиглан хүнс бэлтгэх уралдаан, “Эерэг хандлагыг өөрөөсөө” график зургийн таблет комик ном бүтээх уралдаан • “Сурагч театр” сонгодог жүжгийн дүрийн уралдаан зэрэг олон талт уралдаан, тэмцээнүүдийг сурагчдын дунд зохион байгуулсан. Дээрх уралдаан тэмцээнүүдэд давхардсан тоогоор ЕБС-ийн бага, дунд, ахлах ангийн 980 гаруй сурагч хамрагдсан байна.		
14.	2.1.4 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургууль, МСҮТ-үүдэд	Хамтарч зохион байгуулсан арга хэмжээний тоо	2 арга хэмжээ зохион байгуулсан	-	2 арга хэмжээ	ОХУ-ын Ангарск мужид зохион байгуулагдах “Гагнуурын ур чадварын уралдаан” болон Эрхүү хотод зохион байгуулагдах	2024.01.01 - 2024.12.31	70

	дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллах					“Барилгын мужааны ур чадварын уралдаан”-д оролцсон Орхон аймгийн Политехник коллежийн багш, сурагчдын замын зардалд орон нутгийн төсвөөс 3.2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Мөн “Эрдэнэт цогцолбор” дээд сургуулиас ирүүлсэн 2025 онд хамтран ажиллах саналуудаас хэлтсийн чиг үүрэгт хамаарах удирдлагын манлайлал, харилцаа хандлагын сургалтуудыг тус сургуулийн “Хүний хөгжлийн төв”-ийн багш нартай хамтан 2025 оны “Соёлыг түгээе” аяны хүрээнд зохион байгуулахаар төлөвлөсөн.		
15.	2.1.5 ЕБС, СӨББ-ыг шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, эд хогшлоор хангах	Шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, эд хогшлоор хангагдсан сургууль, цэцэрлэгийн тоо	Төрийн өмчийн 17 сургууль, 39 цэцэрлэгийг тоног төхөөрөмжөөр хангасан.	-	6 сургууль, 6 цэцэрлэг	Тайлант хугацаанд төрийн өмчийн 31 цэцэрлэгийг орон нутгийн төсвийн 500.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар шаардлагатай тоног, төхөөрөмж техник хэрэгслээр хангасан. Мөн “Тэгш боломж” төслийн хүрээнд орон нутгийн төсвийн 150.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 3 сургуульд “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих танхим” –ын тоног, төхөөрөмж, техник хэрэгслүүд, “Эрүүл хүүхэд” төслийн хүрээнд 1 сургуульд “Эрүүл мэндийн жишиг кабинет”-ын тоног, төхөөрөмж, техник хэрэгслүүд, “Хүүхдийн хөгжил” төслийн хүрээнд 17 сургуульд 150.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүн олгогдсон байна.	2024.01.01 - 2024.06.01	100
16.	2.1.6 Хүүхдийг цахим халдлагаас урьдчилан сэргийлэх, цахим хэрэглээний зохист байдлыг бий болгох сургалтуудыг ЕБС-ийн хэмжээнд тогтмол зохион байгуулах	Зохион байгуулсан сургалтын тоо	3 сургалт	2 сургалт	2 сургалт	2024-2025 оны хичээлийн жилд “Хүүхэд хамгааллын тухай хууль” хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан сургууль, цэцэрлэгийн хүүхэд хамгааллын багууд “Гэр айлчлал” хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Ингэснээр хүүхдийн амьдарч буй орчин нөхцөлд дүгнэлт хийж, эрсдлийг илрүүлэх, эрэмблэх, бууруулах, холбон зуучлах зэрэг	2024.01.01 - 2024.12.31	70

44

						хариу үйлчилгээг шаардлагатай хүүхдүүдэд үзүүлж байна. Тайлант хугацаанд ЕБС-иудын "Нийгэм сэтгэл зүйн алба"-наас цахим хуудсаараа дамжуулан 19737 хүнд цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөмж, мэдээллийг хүргэсэн байна.		
17.	2.1.7 Боловсролын чиглэлээр улс, бүсийн чанартай 1-ээс доошгүй арга хэмжээг жил бүр орон нутагтаа зохион байгуулах (Олимпиад, уралдаан, тэмцээн, хурал, зөвлөгөөн)	Зохион байгуулсан сургалтын тоо	1 арга хэмжээ зохион байгуулсан	1 арга хэмжээ	-	Монгол хэл бичгийн улсын 53 дугаар олимпиадыг 2024 оны 5 дугаар сарын 6,7-ны өдөр 14 дүгээр сургууль дээр зохион байгуулсан. Олимпиадад 21 аймаг 9 дүүргийн 60 багш, 30 сурагч оролцсон. Олимпиадын мэргэжлийн багшийн төрөлд 1-р байранд Сэлэнгэ аймаг, 2-р байранд Баянзүрх дүүрэг, Дорнод аймаг, 3-р байранд Увс, Хөвсгөл, Ховд аймгийн багш нар, сурагчийн төрлийн 1-р байранд Төв аймаг, 2-р байранд Хэнтий, Завхан, Сүхбаатар аймаг, 3-р байранд Баянгол, Сүхбаатар дүүрэг, Өмнөговь, Өвөрхангай аймгийн сурагчид тус тус шалгарсан байна. Олимпиадын үйл ажиллагаанд орон нутгийн төсвөөс 39.9 сая төгрөг зарцуулсан.	2024.04.15 - 2024.05.07	100
18.	2.1.8 "Багш" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	90.3 хувь	-	100 хувь	Аймгийн ИТХ-ын 2021 оны 06 дугаар тогтоолоор "Багш" хөтөлбөрийг 3 зорилт 17 арга хэмжээ, 20 үйл ажиллагаатай баталж, багш нарыг судалгаа шинжилгээний ажил хийх арга зүйд суралцуулах, анги удирдсан багшийг мэргэшүүлэх, хөгжүүлэх, багш, ажилтны ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх, Математик, Монгол хэлний хичээлийн сургалтыг сайжруулах, элсэлтийн ерөнхий шалгалт, анги нийтийн сургалтын чанарыг дээшлүүлэх зэрэг олон шинэлэг арга хэмжээг тусган хэрэгжүүллээ. Хөтөлбөрийн 2021 оны хэрэгжилт 88.2, 2022 оны хэрэгжилт 93.3, 2023 оны хэрэгжилт 94.7 хувьтай тус тус	2024.01.01 - 2024.12.31	90

25

						үнэлэгдсэн. 2024 онд хөтөлбөрийн үнэлгээ урьдчилсан гүйцэтгэлээр 90 хувьтай байна. Хөтөлбөрийн хүрээнд явагдсан ЭЕШ-ын чанарыг дээшлүүлэх олон талт арга хэмжээний үр дүнд хэмжээст онооны аймгийн дундаж 2020 онд 507 байсан бол 2021 онд 547.55, 2022 онд 550.33, 2023 онд 553.0, 540.8 болж тогтмол өссөн байна. Багш, ажилтнуудад чиглэсэн төрөл бүрийн сургалт үйл ажиллагааны үр дүнд сургууль, цэцэрлэгүүдийн гүйцэтгэлийн үнэлгээний хувь дээшилсэн байна. Боловсролын үнэлгээний төвтэй хамтран зохион байгуулсан багшийн гүйцэтгэлийн үнэлгээгээр 1-4 дүгээр түвшинд үнэлэгдэж урамшуулал авч буй ЕБС, СӨББ-ын багшийн тоо 2022 онд 536 байсан бол 2024 онд 639, байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагдсан төрийн өмчийн цэцэрлэгүүдийн дундаж үнэлгээ 2022 онд 88.02 хувь байсан бол 2024 онд 88.9 хувь, ЕБС-иудын үнэлгээ 2022 онд 74.3 хувь байсан бол 2024 онд 75.9 хувь болж тус тус өссөн үзүүлэлттэй байна. Мөн сургалтын чанарын үзүүлэлт 2020 онд 80.5 хувь байсан бол 2021 онд 89%, 2022 онд 82.6%, 2023 онд 85.2%, 2024 онд 85.4% хувь болж өссөн байна.		
Зорилт 3. "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах" зорилтын хүрээнд								
19.	3.1 ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж,	Тайлан мэдээг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн эсэх	Тайлан мэдээг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн	Биелэлтийг эхний хагас жилийн байдлаар гаргаж тогтоосон хугацаанд хүргүүлсэн байна.	Биелэлтийг жилийн эцсийн байдлаар гаргаж тогтоосон хугацаанд хүргүүлсэн байна.	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж 2024 оны 1-р улиралд батлуулсан. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь	2024.01.01 - 2024.12.31	100

	холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх					гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлж ажилласан.		
20.	3.2 Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.	Ёс зүйн болон бусад зөрчил гаргаагүй байх	Ёс зүйн болон бусад зөрчил гаргаагүй	Хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан байх	Хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан байх	Албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан чиг үүргийн дагуу холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.	2024.01.01 - 2024.12.31	100
21.	3.3 Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх	Шийдвэрлэсэн өргөдөл гомдлын тоо	41 өргөдөл, хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэсэн.	Өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэж хариуг өгсөн байх	Өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэж хариуг өгсөн байх	Иргэдээс ирүүлсэн 51 өргөдөлийг шийдвэрлэж хариуг хугацаанд нь өгсөн.	2024.01.01 - 2024.12.31	100
22.	3.4 Засаг дарга, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр байгуулагдсан ажлын хэсэг, комисст ажиллах, өгөгдсөн үүрэг даалгаврыг шуурхай гүйцэтгэх	Комисс, ажлын хэсэгт ажилласан тоо	9	Шийдвэрийн дагуу ажиллах	Шийдвэрийн дагуу ажиллах	Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын шуурхай хурлаас ирүүлсэн 36 удаагийн үүрэг даалгаврыг биелүүлж, хариуг хүргүүлсэн. Мөн аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан 9 ажлын хэсэгт орж ажилласан.	2024.01.01 - 2024.12.31	100

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/Д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Монгол хэлний хичээлийн улсын 53	-	-	Монгол хэлний хичээлийн улсын	Монгол хэл бичгийн улсын 53 дугаар олимпиадыг 2024 оны 5 дугаар сарын 6,7-ны	2024.04.15- 2024.05.07	100

229


	дугаар олимпиадыг зохион байгуулах Ажлын хэсэг			53 дугаар олимпиадыг бэлтгэл хангаж зохион байгуулсан байна.	өдөр 14 дүгээр сургууль дээр зохион байгуулсан. Олимпиадад 21 аймаг 9 дүүргийн 60 багш, 30 сурагч оролцсон. Олимпиадын мэргэжлийн багшийн төрөлд 1-р байранд Сэлэнгэ аймаг, 2-р байранд Баянзүрх дүүрэг, Дорнод аймаг, 3-р байранд Увс, Хөвсгөл, Ховд аймгийн багш нар, сурагчийн төрлийн 1-р байранд Төв аймаг, 2-р байранд Хэнтий, Завхан, Сүхбаатар аймаг, 3-р байранд Баянгол, Сүхбаатар дүүрэг, Өмнөговь, Өвөрхангай аймгийн сурагчид тус тус шалгарсан байна. Олимпиадын үйл ажиллагаанд орон нутгийн төсвөөс 39.9 сая төгрөг зарцуулсан.		
2.	“Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг зохион байгуулах Ажлын хэсэг	-	-	“Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийн соёл, урлагийн арга хэмжээг бэлтгэл хангаж зохион байгуулсан байна.	“Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийн соёл, урлагийн арга хэмжээний бэлтгэлийг хангаж боловсрол, соёл, спортын 800 гаруй хүүхдээс бүрдсэн урлаг, спортын тоглолтыг 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулсан.	2024.05.15- 2024.06.01	100
3.	Монголын тулгар төрийн 2233, Их Монгол улс байгуулагдсаны 818, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 113, Ардын хувьсгалын 103, Эрдэнэт хот, Эрдэнэт үйлдвэрийг бүтээн босгосон “Илгээлтийн эзэд”-ийн 50 жилийн ой, Орхон аймгийн баяр наадмыг хурдан морьдын бүсийн уралдааныг зохион байгуулах ажлын хэсэг	-	-	Наадмын нээлт, хаалт, үдшийн цэнгүүний арга хэмжээг зохион байгуулсан байна.	Монголын тулгар төрийн 2233, Их Монгол улс байгуулагдсаны 818, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 113, Ардын хувьсгалын 103, Эрдэнэт хот, Эрдэнэт үйлдвэрийг бүтээн босгосон “Илгээлтийн эзэд”-ийн 50 жилийн ой, Орхон аймгийн баяр наадмын нээлт, хаалт, үдшийн цэнгүүний арга хэмжээг аймгийн СУАЖЗГ, ХЗТ, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Соёл, урлагийн цогцолбор, соёлын төвүүдтэй хамтран зохион байгуулсан.	2024.07.15 2024.08.05	100
4.	“Эрдэнэт хотын болон Анхдагч илгээлтийн эздийн өдөр”-ийн арга хэмжээг зохион байгуулах Ажлын хэсэг	-	-	Арга хэмжээний хүрээнд явагдах соёл, урлагийн арга хэмжээний бэлтгэлийг хангаж зохион байгуулсан.	Арга хэмжээний нэгдсэн хөтөлбөрийг гаргаж, шаардагдах зардлыг аймгийн Засаг даргын захирамжаар шийдвэрлүүлсэн. Улсын филарманийн “Баян Монгол” чуулгын тоглолт, Эрдэнэт хотын сүлд модны гэрэл асаах ёслол, “Эрдэнэт хотын түүх” сэдэвт хичээл зэрэг арга хэмжээг бэлтгэл хангаж зохион байгуулсан.	2024.11.28 2024.12.11	100

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
Зорилт 1. "Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх" зорилтын хүрээнд							
1.	2.1 Мэргэшүүлэх сургалтад хамрагдах	Сургалтад хамрагдсан эсэх	Төрийн албаны дунд хугацааны мэргэшүүлэх сургалтад хамрагдсан	Зохион байгуулагдсан сургалтуудад хамрагдсан байна.	"Бага насны хүүхдийн цогц хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх нь" сургалт болон "Үр дүнд суурилсан төлөвлөлт" сургалтууд болон УА-ын Ахлах түшмэлийн сургалтад хамрагдсан.	2024.04.29-2024.12.31	100
2.	2.2 Албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг чадвараа дээшлүүлэх холбогдох хууль тогтоомжийг судлах, сургалтад хамрагдах	Сургалтад хамрагдсан эсэх	ТАЗ, Боловсролын яам, Соёл, спорт, аялал жуучлал, залуучуудын яамнаас зохион байгуулсан цахим сургалтуудад бүрэн хамрагдсан.	Зохион байгуулагдсан сургалтуудад хамрагдсан байна.	ТАЗ, БШУ-ны яам, Соёлын яамнаас зохион байгуулсан цахим сургалтуудад бүрэн хамрагдсан.	2024.01.01-2024.12.31	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

Аймгийн ЗДТГ-ын НБХ-ийн мэргэжилтэн

А.Отгонбаяр / 

2024.12.05

(Албан тушаал)

(Нэр, гарын үсэг)

(Огноо)

68